



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2018 оны 2 дугаар сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 2 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 20%-иар буюу 265 сая ам.доллараар өсч 1,564 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 3%-иар буюу 26 сая ам.доллараар өссөн, импорт 49%-иар буюу 239 сая ам.доллараар өссөн нь нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 213 сая ам.доллараар буурч 112 сая ам.долларын ашигтай байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 2 сар			Өөрчлөлт			
	2015	2016	2017	2016/2015		2017/2016		2016	2017	2018	2017/2016		2018/2017	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,467	8,274	10,536	(192)	-2%	2,262	27%	965	1,299	1,564	334	35%	265	20%
Экспорт	4,669	4,916	6,201	247	5%	1,284	26%	613	812	838	199	32%	26	3%
Импорт	3,798	3,358	4,335	(439)	-12%	977	29%	352	487	726	135	38%	239	49%
Тэнцэл	872	1,558	1,865	686		307	20%	261	326	112	64	25%	(213)	-65%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2018 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 191 сая ам.доллараар буурч 150 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 60% буюу 945 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 16% буюу 251 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 70%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 4.1%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 1%-иар буурсан бол өмнөх сараас 3%-иар өсч 1.771-д хүрлээ. Тайлант сард түүхий эдийн экспортын хилийн үнэ өссөнөөс голлон шалтгаалж худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирчээ.

Экспорт 22018 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 3.2%-иар буюу 26 сая ам.доллараар өсөв. Тухайлбал аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт болон түүхий эдийн экспорт өссөн нь нийт экспортыг харгалзан 2.7, 0.5 нэгж хувиар өсөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2.4 нэгж хувиар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувь 2.5 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
1. Уул уурхай		525	86%	758	93%		762	91%		233	44%	38%	4	1%	0.5%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	274	334	54%	241	246	30%	205	275	33%	(88)	-26%	-14%	28	11%	3%
1.2. Чулуун нүүрс	1,431	44	7%	4,792	326	40%	3,149	242	29%	282	642%	46%	(83)	-26%	-10%
1.3. Боловсруулаагүй нефть	1,429	44	7%	1,126	59	7%	1,010	63	7%	15	33%	2%	4	7%	0%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	572	16	3%	713	45	6%	932	40	5%	29	183%	5%	(5)	-12%	-1%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	1,697	64	10%	778	31	4%	1,696	72	9%	(33)	-52%	-5%	41	135%	5%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	11	10	2%	19	27	3%	21	37	4%	17	175%	3%	10	38%	1%
1.7. Жонош, лейцит, нефелинт	32	7	1%	33	8	1%	49	16	2%	0	4%	0%	8	103%	1%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	1	4	1%	1	6	1%	1	6	1%	1	34%	0%	0	7%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	1	0%	0	1	0%	0	1	0%	(1)	-63%	0%	0	0%	0%
1.10. Мөнгө /тонн/	4	1	0%	0	-	0%	0	0	0%	(1)	-100%	0%	0	0%	0%
1.11. Бусад	5	0	0%	83	10	1%	106	11	1%	10	2486%	2%	0	0%	0%
2. Мал аж, ахуй	51	24	4%	82	29	4%	87	29	4%	5	23%	1%	0	2%	0.1%
2.1. Амьд мал, малын мах	1	2	0%	2	4	0%	5	11	1%	2	120%	0%	7	195%	1%
2.2. Арьс, шир	48	10	2%	77	7	1%	80	5	1%	(2)	-25%	0%	(3)	-37%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	1	0%	0	1	0%	0	1	0%	0	38%	0%	0	0%	0%
2.4. Ноолуур	1	9	1%	1	15	2%	1	11	1%	6	68%	1%	(4)	-29%	-1%
2.5. Ноос, бусад үс, хялгас	2	3	0%	1	2	0%	1	2	0%	(1)	-28%	0%	(0)	-16%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	880%	0%	0	47%	0%
3. Газар тариалан	16	3	1%	2	1	0%	1	0	0%	(2)	-74%	0%	(0)	-41%	0.0%
4. Аж үйлдвэрлэл	33	61	10%	66	25	3%	11	47	6%	(36)	-59%	-6%	22	87%	2.7%
4.1. Хүнс	2	10	2%	3	10	1%	5	17	2%	0	4%	0%	7	66%	1%
4.2. Ноолууран эдлэл	0	2	0%	0	3	0%	0	3	0%	1	74%	0%	1	27%	0%
4.3. Бусад хувцас, пүтэл, эдлэл	0	2	0%	0	2	0%	1	2	0%	(0)	-12%	0%	1	26%	0%
4.4. Уул уурхай	4	11	2%	6	5	1%	4	17	2%	(6)	-55%	-1%	12	236%	2%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-72%	0%	0	303%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	0	36	6%	0	4	0%	0	5	1%	(32)	-89%	-5%	1	34%	0%
4.7. Бусад	27	0	0%	58	1	0%	0	1	0%	1	163%	0%	(0)	-8%	0%
5. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-28%	0%	(0)	-27%	0.0%
Нийт дүн		613		812			838			199	32%		26	3.2%	


%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2018 оны 2 дугаар сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	(122.5)		126.6		4	1%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(47.4)	-167%	75.7	267%	28.3	11%
1.2. Чулуун нүүрс	(126.6)	152%	43.3	-52%	(83)	-26%
1.3. Боловсруулаагүй нефть	(7.2)	-177%	11.2	277%	4	7%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	9.3	-175%	(14.7)	275%	(5.3)	-12%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	39.1	94%	2.3	6%	41.4	135%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	4.3	42%	5.9	58%	10.2	38%
1.7. Жонош, лейцит, нефелинт	5.1	64%	2.8	36%	8.0	103%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(1.4)	-356%	1.8	456%	0.4	7%
1.11. Бусад	2.2		(2.2)		0.0	0%
2. Мал аж, ахуй	8.5		(8.0)		0.5	2%
2.1. Амьд мал, малын мах	6.2	84%	1.2	16%	7.4	195%
2.2. Арьс, шир	0.2	-6%	(2.9)	106%	(2.8)	-37%
2.4. Ноолуур	1.8	-41%	(6.1)	141%	(4.4)	-29%
3. Газар тариалан	(0.5)	142%	0.1	-42%	(0.3)	-41%
4. Аж үйлдвэрлэл	(115.7)		137.4		21.7	87%
5. Бусад	(0.2)	504%	0.1	-294%	(0.0)	-27%
Нийт дүн	(230)		256		26	3%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2018 оны эхний 2 сард экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 230 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 256 сая ам.доллараар өссөн байна. Уул уурхайн түүхий эдийн экспорт нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ буурснаас шалтгаалж 174 сая ам.доллараар буурсан байна. Харин мал аж, ахуйн түүхий эдийн экспортын тоо хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалж 8.5 сая ам.доллараар өсчээ. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын үнэ өссөнөөс шалтгаалж 137 сая ам.доллараар өссөн байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2018 оны 2 дугаар сард 1,332 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8%-иар өссөн, өнгөрсөн сараас 0.02%-иар буурсан байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 7,007, 77 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 18%-иар өсч, төмрийн хүдэр 14%-иар буурсан бол, өнгөрсөн сараас зэс 0.8%-иар буурсан, төмрийн хүдэр 1.5%-иар өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 2 дугаар сард 87 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 22%-иар, өмнөх сараас 24%-иар өссөн байна.

Импорт 2018 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 49%-иар буюу 239 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 17 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 11 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүн болон аж үйлдвэрийн орц бүтээгдэхүүний өсөлт тус бүр 10 нэгж хувийг тайлбарлаж байна.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		128	36%		159	33%		209	29%	31	24%	9%	50	31%	10%
Түргэн эдлэгтэй	101	74	21%	148	91	19%	137	115	16%	18	24%	5%	24	26%	5%
Хүнс	48	50	14%	47	59	12%	64	81	11%	9	18%	3%	21	36%	4%
Эм, тариа	0	9	3%	0	14	3%	0	14	2%	4	46%	1%	1	5%	0%
Бусад түргэн эдлэгтэй бараа	52	14	4%	101	18	4%	72	20	3%	4	30%	1%	2	9%	0%
Удаан эдлэгтэй	18	54	15%	43	68	14%	22	94	13%	14	25%	4%	26	39%	5%
Гутал, хувцас, цүнх	8	6	2%	13	7	2%	7	10	1%	2	30%	0%	2	32%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	2	12	3%	21	16	3%	7	18	2%	5	39%	1%	2	1%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	0	29	8%	0	37	8%	0	55	8%	8	29%	2%	18	48%	4%
Бусад удаан эдлэгтэй бараа	9	8	2%	9	7	1%	7	11	2%	(1)	-1%	0%	4	56%	1%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	157	105	30%	126	158	32%	243	241	33%	53	50%	15%	83	53%	17%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	2	63	18%	5	118	24%	3	154	21%	55	88%	16%	35	30%	7%
Сүүдлэс бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	11	3%	0	18	4%	0	48	7%	7	65%	2%	29	163%	6%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	2	52	15%	5	100	21%	3	106	15%	48	93%	14%	6	6%	1%
Барилгын материал	39	23	6%	28	24	5%	47	51	7%	1	3%	0%	27	115%	6%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	3	19	6%	4	16	3%	5	37	5%	(3)	-17%	-1%	21	130%	4%
Аж үйлдвэрлэлийн орц	111	64	18%	176	66	14%	236	115	16%	2	4%	1%	49	75%	10%
Хүнсний орц	54	11	3%	6	2	0%	71	27	4%	(9)	-80%	-3%	25	1121%	5%
Химийн бүтээгдэхүүн	13	9	3%	19	11	2%	29	16	2%	2	19%	0%	5	47%	1%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	2	2	0%	3	3	1%	7	3	0%	1	62%	0%	1	24%	0%
Цахилгаан эрчим хүч	0	13	4%	0	21	4%	0	23	3%	8	64%	2%	2	12%	1%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-91%	0%	0	91%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	87	28	8%	97	29	6%	135	45	6%	1	4%	0%	16	54%	3%
Нефтийн бүтээгдэхүүн	111	54	15%	176	102	21%	236	157	22%	48	87%	14%	55	54%	11%
Дизель түлш	53	23	7%	99	53	11%	151	97	13%	30	127%	8%	44	82%	9%
АИ-92, АИ-95	43	21	6%	53	32	7%	48	33	5%	11	53%	3%	1	2%	0%
А-80 болон бусад	15	10	3%	23	17	3%	37	27	4%	7	68%	2%	11	65%	2%
Бусад	1	0	0%	3	1	0%	35	1	0%	1	164%	0%	0	10%	0%
Нийт дүн		352		487			726			135	38%		239	49%	


%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2018 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	12.2	24%	37.7	76%	50	31%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	(28.4)		113.0		85	54%
Аж үйлдвэрлэлийн орц	47.3	96%	1.9	4%	49.3	75%
Нефтийн бүтээгдэхүүн	39.9	72%	15.5	28%	55.3	54%
Дизель түлш	33.0	75%	10.9	25%	43.8	82%
АИ-92, АИ-95	(3.5)		4.2		0.7	2%
А-80 болон бусад	10.4	96%	0.4	4%	10.8	65%
Бусад	1.2		(1.1)		0.1	10%
Нийт дүн	72	30%	167	70%	239	49%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2018 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр импорт нь тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 73 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 166 сая ам.доллараар өсчээ. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт нь тоо хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалж 12 сая ам.доллараар өсчээ. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 53%-иар өссөн нь үнийн өөрчлөлтөөс голлон шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ 54%-иар өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2018 оны 2 дугаар сард өмнөх сараас 2 хувиар, өмнөх оны мөн үеэс 12 хувиар өсч тонн тутамд 672 ам.долларт хүрэв.